

УЛИАСТАЙ СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



Огноо: 2019 оны 7 дугаар сар 26-ны өдөр

**“ТОВЦОГ, ӨЛЗИЙТ, ЖАРГАЛАНТ, ЧИГЭСТЭЙ, БОГДЫН ГОЛ БАГУУДЫН ОРОН
СУУЦ, ГЭР ХОРООЛОЛД ШИНЭЭР ХАЯГЖУУЛАЛТ ХИЙХ” АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: ТОВЦОГ, ӨЛЗИЙТ, ЖАРГАЛАНТ, ЧИГЭСТЭЙ, БОГДЫН ГОЛ
БАГУУДЫН ОРОН СУУЦ, ГЭР ХОРООЛОЛД ШИНЭЭР ХАЯГЖУУЛАЛТ ХИЙХ

Төслийн дугаар: 01-ХА-03/2019

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Завхан аймаг Улиастай сум Засаг Даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Товцог, Өлзийт, Жаргалант, Чигэстэй, Богдын гол багуудын орон сууц, гэр хороололд шинээр хаягжуулалт хийх” тендерийн үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул баримт бичгийг татаж авна уу.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерт оролцогч нь холбогдох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, эрх бүхий хуулийн этгээд байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө тендерт оролцох хураамж болох 50000 /Тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг **2019 оны 8 дугаар сар 8-ны өдрийн 10 цаг 30 минутаас** өмнө ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 8 дугаар сар 8-ны өдрийн 11 цаг 00 минут**-т нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Захиалагчийн хаяг: Завхан аймаг, Улиастай сум, Жинст баг Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын байрны 1 давхар 105 тоот өрөө,
Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн
утас: 88466861**

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн бол нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-Д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүчин төгөлдөр Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байх. 2. Үндэсний татварын цахим системийг ашиглан авсан татварын тодорхойлолт. 3. Татварын газрын тодорхойлолт / татварын өргүй байх, эх хувь/ 4. Шүүхийн байгууллагын тодорхойлолт /эх хувь/ 5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /эх хувь/ 6. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт 7. Харьяалагдах банкны тодорхойлолт /тулгамдсан өргүй байх, эх хувь/ 8. Захиалагч татварын байгууллага болон бусад холбогдох газруудаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлэх.
ТӨӨЗ 2.1	<p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Улиастай Сум ЗДТГ, Тендер хүлээн авах этгээд: С.Мөнхтулга Байгууллагын хаяг: Завхан аймаг. Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын байр Давхар болон өрөөний дугаар: 1-р давхар 105 тоот Аймаг, хот: Завхан аймаг. Улиастай сум Шуудангийн дугаар: Байхгүй Улс: Монгол Улс Тендер хүлээн авах эцсийн хугацаа: 2019 он 08-р сар 15-ны өдөр Цаг: [17 цаг 30 минут]</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: Завхан аймаг. Улиастай сумын Засаг даргын тамгын газрын байр Давхар болон өрөөний дугаар: 2-р давхар 202 тоот өрөөнд Аймаг, хот: Завхан аймаг. Улиастай сум Шуудангийн дугаар: байхгүй Улс: Монгол Улс Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Цаг: [71 цаг 40 минут]</p>
ТӨӨЗ 3.1	<p>- Үнийн санал - Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарийг ирүүлэх</p>
ТӨӨЗ 3.1(в)	<ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оний санхүүгийн тайлан ирүүлэх. 2. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн буюу 2017, 2018 он Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундуж нь санал болгож буй үнийн дүнгээс 50% -иас багагүй байна. 3. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: Сүүлийн 3 жил [2016, 2017, 2018 он] Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 оны дундаж буюу 50 хувь нь санал болгож байгаа үнийн дүнгээс багагүй ижил төстэй ажлын гэрээнд /тусгай зөвшөөрлийн хүрээнд/ үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлагатай байна. Ажил гүйцэтгэсэн гэрээний

ТӨӨЗ 3.1(в)	<p>хуулбар, улсын комисс хүлээж авсан актын хуулбар, фото зураг, тухайн ажлыг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн тухай захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.</p> <p>4. Ашигтай ажилласан байх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2017, 2018он</p>
ТӨӨЗ 3.1(г)	Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: Үгүй
ТӨӨЗ 3.1(д)	<ol style="list-style-type: none"> 1. Тендерт оролцогчийг төлөөлөн гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ. Захирал өөрөө гарын үсэг зурж буй тохиолдолд итгэмжлэл шаардлагагүй. 2. Тендерийн баримт бичгийн 8, 9 дүгээр бүлэгт заасан гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг зөвшөөрч байгаа эсэх талаар мэдэгдэл ирүүлнэ. 3. Ажлын талбайтай танилцсан тэмдэглэл ирүүлнэ. 4. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ. 5. Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалт. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Хавтан зүсэх багаж / Суурин хөрөө/ • Хуулга зүсэгч /плотерийн машин/ гэх мэт <p>Жич: Техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТӨӨЗ 6.1	Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Мөрдөх норм стандарт, дүрэм

1. 2013 оны Засгийн газрын 280 дугаар тогтоол” Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”

2. “Монгол улсын ” Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага “ MNS 5283:2014 стандарт

Техникийн шаардлага :

1. Хаягийн самбарын материал нь MNS 5283:2014 стандартад заасны дагуу байгалийн үзэгдэлд тэсвэрлэхүйц, зэвэрдэггүй металл байх эсвэл хамгаалалтын гадаргуутай байна.
2. Гудамж хашааны хаягийн төмрийн зузаан нь **2-3мм**, бусад тэмдэгийн зузаан нь **3- 5мм** байна.
3. Хашааны хаалганы тэмдгийг явган хаалганы баруун талд стандартад дурьдсан хэмжээнд байна.
4. Хаягийн тэмдгийн дэвсгэр нь RGB/0.131.73/ код бүхий ногоон өнгөтэй, байгалийн аливаа үзэгдэлд хуурч гандахгүй, шөнийн цагт саадгүй харагдах, тээврийн хэрэгсэлийн болон бусад төрлийн гэрлийн тусгалаар гэрэлтдэг материалаар хийсэн байх.
5. Хаягийн тэмдгийн тулгуур суурийг барилгын зургийн инженерийн зураг төслөөр хийж, хянаж шалгасан , батлагдсан орц, нормын дагуу хийж, байгалийн аливаа үзэгдэлд тэсвэртэй, мал амьтан налж, шөргөөхөд унахааргүй бат бөх суурилуулсан байх.
6. Хаягийн самбарыг ангилал төрлөөс хамааран стандартад заасан хэмжээгээр хийж гүйцэтгэсэн байх.
7. Хаягийн тэмдэг нь гүйцэтгэгч 5-н жилийн баталгаа гаргаж өгөхүйц чанартай байна.
8. Гүйцэтгэсэн ажлын талаар дэлгэрэнгүй тайландаа тодорхой тусгасан байна.
9. Гэр хорооллын гудамжны хаягийн тэмдгийн баруун үзүүрт тухайн гудамжинд хамаарах хашаануудын дугаарыг бичсэн байна.

Бараа материалын захиалга:

1. Гэр хорооллын гудамжны хаягийн тэмдэг /400*120/ хэмжээтэй - 500 ширхэг хаяг
2. Байшин барилгын дугаар /500*500/ хэмжээтэй - 7 ширхэг хаяг
3. Орон сууцны орцын дугаар /400*120/хэмжээтэй- 21 ширхэг хаяг
4. Хашааны дугаар /150*100/ хэмжээтэй - 4500 ширхэг хаяг

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН
МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын _____ танаа
дарга

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад

нөхцөл: Тендерт

оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг,

тамга: Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГГИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Захиалагч,

Гэрээний нэр	холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 5 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-ээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)⁴ 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

³

⁴

Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____ (Тамга, тэмдэг)	_____ (Тамга, тэмдэг)
_____ (Гарын үсэг)	_____ (Гарын үсэг)
_____ (Албан тушаал)	_____ (Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр]
гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний
дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө
талаас
[нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан
тохиролцож
____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр,
_____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг ____ оны __ дугаар сарын __-аас ____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл; Бусад шаардлагатай баримт бичиг⁶;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл; Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь; Санхүүжилтийн хуваарь.

⁵ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁶ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудангаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

*[Албан тушаал,
нэр] [Гарын үсэг]*

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын
дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны
дугаар]*

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

*[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]*

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*